



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай орон сууц корпораци ХХК-ний 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/08/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 7033-3019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.15 № 123
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ ОРОН СУУЦ
КОРПОРАЦИ ХХК-НИЙ ЗАХИРАЛ
М.ГҮРСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Архангай орон сууц корпораци ХХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай орон сууц корпораци ХХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тус компани нь 2022 онд Компаний дүрмийн 9.7.3 "Компаний үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот төвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, аймгийн засаг даргад танилцуулж, батлуулах", 9.7.4-т "Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, хувьцаа эзэмшигчдийн хурлын болон аймгийн засаг даргын шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэсний дагуу тайлант жилийн орлого, зардал, ашиг алдагдлыг тооцож ажиллаагүй байна.
- Дүрмийн 1.3-т компаний үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээд гэж заасны дагуу тайлангийн жилд өөрийн орлого бүрдүүлэх, төвлөрүүлэх талаар үйл ажиллагаа хийгдээгүй, аймгийн засаг даргын нөөц сангаас 33,500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаа явуулсан байна.

Энэхүү зөрчил нь тооцсон материаллаг байдлын түвшнээс дээгүүр байгаа бөгөөд аудитын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1.00	ХӨРӨНГӨ		
1.10	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	21,770.00
1.1.6	Бараа материал	-	-
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	21,770.00
1.20	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	4,956,432.00
1.2.2	Биет бус хөрөнгө		-
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	4,956,432.00
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	4,978,202.00
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.10	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.20	Өр төлбөрийн нийт дүн	-	-
	Эздийн өмч		
2.30	Өмч :		
2.3.1	а) төрийн		4,789,000.00
2.3.2	б) хувийн		
2.3.3	в) хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-	189,202.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	-	4,978,202.00
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	-	4,978,202.00

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		-
6	Ногдол ашгийн орлого		-
7	Хандив тусламжийн орлого		33,500,000.00
8	Бусад орлого		50,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	
10	Ерөнхий ба удирдлагын зардал		33,360,798.00
11	Санхүүгийн зардал		-
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-

16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-
17	Бусад ашиг (алдагдал)		-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	189,202.00
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	189,202.00
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	189,202.00
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-	189,202.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	33,550,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	33,500,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	50,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	32,248,130.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	26,498,530.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	1,050,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	2,100,000.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	1,854,560.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	377,740.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	367,300.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	1,301,870.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	1,280,100.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	1,280,100.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	(1,280,100.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-

**Архангай орон сууц корпораци ХХК-ний 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	21,770.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	21,770.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-	-
3	Залруулсан үлдэгдэл			-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт			-	-
7	Зарласан ногдол ашиг			-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-	-
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-			-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			189,202.00	189,202.00
13	Бусад дэлгэрэнгүй орлого				-
14	Өмчид гарсан өөрчлөлт				-
15	Зарласан ногдол ашиг				-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
17	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	-	-	189,202.00	189,202.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,967.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Үүнд: 1,854.5 мянган төгрөгийн бараа материалыг бараа материалын дансаар дамжуулан бүртгээгүй, 1,112.7 мянган төгрөгийн тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцож бүртгээгүй алдааг санхүүгийн тайланд залрууллаа.

Аудитаар залруулагдаагүй нийт 36,627.0 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 4 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

3.2.1. Тус компани нь 2022 онд компаний үйл ажиллагааны зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг боловсруулан аймгийн засаг даргаар батлуулаагүй, аймгийн засаг даргын нөөц сангаас 33,500.0 мянган төгрөгийн дэмжлэг авч ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 " ..., санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Компаний дүрмийн 9.7.3-т " Компаний үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот төвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, аймгийн засаг даргад танилцуулж, батлуулах", 9.7.4-т "Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, хувьцаа эзэмшигчдийн хурлын болон аймгийн засаг даргын шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.2. Тус байгууллагын захирал М.Гүрсүрэнгийн цалинг аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны Б/07 тоот захирамжаар сарын үндсэн цалинг 1300,000 төгрөгөөр, менежерийн албан тушаалын сарын цалинг компаний захирлын 2022 оны 02 дугаар сарын 01 тоот тушаалаар 1000,000 төгрөгөөр тус тус тогтоосон байхад нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхдөө цалингийн доод хэмжээ буюу 420.0 мянган төгрөгөөр тооцон төлж нийт 1,846.9 мянган төгрөгийн зөрүү үүсгэсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна",32.1.1-д "Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, ..." гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх, Нийгмийн даатгалын хэлтэст мэдээллийг хүргүүлэх

3.2.3. Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр 1280.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь аймгийн ИТХТ-ийн 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1-д " Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь батлагдсан төсвийн эх үүсвэр болон ажлын зайлшгүй шаардлагаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй саналаа Орон нутгийн өмчийн газарт ирүүлж холбогдох шийдвэрийг гаргуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Архангай ОСК ХХК	2	2967.2	2	2967.2	0	0	2	2967.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Архангай ОСК ХХК	4	36627.0	0	0	4	36627.0	1	0		0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Архангай ОСК ХХК	1	0	0	0	1	0	0	0